



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/772

Арвайхээр

**Аймгийн “Тэмээчдийн баяр-2019” арга хэмжээ
зохион байгуулах тухай**

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 09/07 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн эдийн засгийг 2014-2024 он хүртэл хөгжүүлэх бодлогын баримт бичиг”-ийн 3.1.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тэмээ бүхий сумдууд оролцсон аймгийн “Тэмээчдийн баяр-2019” арга хэмжээг Арвайхээр суманд 2019 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн “Тэмээчдийн баяр-2019” арга хэмжээний үеэр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир спортын газрын дарга (Б.Энхтөр) -д даалгасугай.

3. Хавсралтаар батлагдсан зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд) -т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101636

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2018..... оны 12
дугаар сарын 17...ны өдрийн 1779 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН “ТЭМЭЭЧДИЙН БАЯР”-2019 АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Б.Энхтөр -аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир
спортын газрын дарга

Нарийн бичгийн дарга: С.Цэдэнбалжир -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө
аж ахуйн газрын дарга

Гишүүд: Т.Ариунболд -аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал
жуулчлалын газрын дарга

О.Ганбат -аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

Б.Цэнгэл -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Мал аж ахуйн албаны дарга

А.Нямдаваа -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Мал эмнэлгийн газрын дарга

Н.Баярцэнгэл- аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн
газрын мэргэжилтэн

Ч.Чинзориг -Богд сумын Засаг дарга

Р.Намгилрагчаа -Гучин-Ус сумын Засаг дарга

Д.Баатарчулуун -Баруунбаян-Улаан сумын Засаг дарга

А.Мөнхбат -Баянгол сумын Засаг дарга


Б.Батбаяр -Төгрөг сумын Засаг дарга

Д.Цэвэлсүрэн -“ӨВ-Торгоны зам” ТББ-ын ерөнхий менежер (зөвшилцсөнөөр)

Ж.Намсрайжав -Төгрөг сумын тэмээчдийн холбооны тэргүүн

О.Пүрэвдорж -Арвайхээр сумын Засаг дарга

С.Дамдинпүрэв -Сант сумын Засаг дарга


 Аймгийн Засаг даргын 2018..... оны 12..
 дугаар сарын 17...ны өдрийн 1772 дугаар
 захирамжийн хоёрдугаар хавсралт

**АЙМГИЙН “ТЭМЭЭЧДИЙН БАЯР-2019” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН
 БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Хэрэглэгдэх зүйлс	Зориулалт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Атан тэмээ /медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал/	Тэргүүн	1	ш	1.700.000	1.700.000
		Дэд	1	ш	1.000.000	1.000.000
		Гутгаар	1	ш	800.000	800.000
		Дөтгөөр	1	ш	500.000	500.000
		Айргын тав	1	ш	300.000	300.000
		Тусгай байр	5	ш	100.000	500.000
2.	Тормон тэмээ /медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал/	Тэргүүн	1	ш	1.500.000	1.500.000
		Дэд	1	ш	1.000.000	1.000.000
		Гутгаар	1	ш	800.000	800.000
		Дөтгөөр	1	ш	500.000	500.000
		Айргын тав	1	ш	300.000	300.000
		Тусгай байр	5	ш	100.000	500.000
3.	Сайхан хос /өргөмжлөл, мөнгөн шагнал/	Тэргүүн	1	ш	200.000	200.000
		Дэд	1	ш	180.000	180.000
		Гутгаар	1	ш	150.000	150.000
4.	Шилмэл буур /тууз, өргөмжлөл, мөнгөн шагнал/	Тэргүүн	1	ш	200.000	200.000
		Дэд	1	ш	180.000	180.000
		Гутгаар	1	ш	150.000	150.000
5.	Шилмэл ингэ /тууз, өргөмжлөл, мөнгөн шагнал/	Тэргүүн	1	ш	200.000	200.000
		Дэд	1	ш	180.000	180.000
		Гутгаар	1	ш	150.000	150.000
Дүн						10.990.000